



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Г Компанийн 2015 оны үйл ажиллагааны 7  
болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн  
дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалтыг удирдлага болгон Говь хувьцаат компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр, 2016 оны 4 сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

*Нэг.* Говь хувьцаат компанийн 2015 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ХҮРЭЛБААТАР



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2016 оны 4 сарын 8 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Г  
Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг  
батлах тухай  
Г

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэхь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэхь заалт, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэхь заалт, 2016 оны 4 сарын 8-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь хувьцаат компанийн дүрмийн зүйл, заалтуудын дугаарлалтыг нэгдмэл нэг хэлбэрт оруулж засахыг зөвшөөрсүгэй.

**Хоёр.** Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэхь заалтад заасан Эрх бүхий албан тушаалтанд “Санхүү бүртгэлийн хэлтсийн захирал”-ыг нэмж оруулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.ХҮРЭЛБААТАР

